



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Ахмад настанд ээлтэй байгууллага,
иргэнийг шалгаруулж, шагнах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.15 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2001 оны 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас ахмадын байгууллагатай хамтран ажилладаг, тэдэнд бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлдэг байгууллагуудыг “Ахмад настанд ээлтэй байгууллага”-аар шалгаруулж шагнасугай.

- Үүнд: 1) 2 дугаар хорооны “Түмэн тус” ХХК
2) 12 дугаар хорооны “ГБХ” ХХК
3) 18 дугаар хорооны “Их ханд” цэцэрлэг

2. Ахмад настны төлөө чин сэтгэлээсээ хандаж, эд материалын болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, дүүрэг, орон нутаг, ахмадын байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачлагатай оролцсон дараах иргэдийг “Ахмад настанд ээлтэй иргэн”-ээр шалгаруулж шагнасугай.

- Үүнд: 1) 5 дугаар хорооны иргэн Ж.Алтангэрэл
2) 10 дугаар хорооны иргэн Б.Болортуяа
3) 14 дүгээр хорооны иргэн Б.Должинсүрэн

3. Шаардагдах зардал 1200000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ